



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх,
бэлэн байдлыг хангах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.8 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 346, 2020 оны А/36, А/93 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ажиллагсдын дархлааг дэмжих аяны удирдамжийг 1 дүгээр, аянд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Болзошгүй гамшиг, осол, хордлого, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед ажиллах төлөвлөгөөг мөрдөн, эмнэлгийн яаралтай тусламж, хүний нөөц, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэргэжлийн ангийн нарийн бичгийн дарга /Ч.Далайцэрэн/, Хүний халдварт өвчний дэгдэлтийн үеийн Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн Эрүүл мэндийн сайдын тушаалын хэрэгжилтийг хангаж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цусны чанар, аюулгүй байдлын албаны дарга /Т.Алимаа/, Цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж, шаардлагатай үед ажиллах ажиллагсдын хуваарь гарган бэлтгэлийг хангуулж ажиллахыг Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/, Үйлдвэрлэлийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/, Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/-д тус тус үүрэг болгосугай.

3. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэхэд шаардлагатай хавсралтад заасан дархлаажуулалтын бэлдмэлийг бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Өнөрзул/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, маркетингийн албаны дарга /Ч.Батболд/-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭБАЯР

080328

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2020 оны
11... сарын 05... өдрийн 11/09 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт



“ ДАРХЛААГАА ДЭМЖИЦГЭЭЭ” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго: Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, ажиллагсдын эрүүл мэндийг дэмжих

Хоёр. Зорилт:

- Ажиллагсдын дархлааг дэмжих;
- ТТТӨ-өөс урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажиллагсдын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх;

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Дархлаа дэмжих цэгэн иллэгийг ажилтан бүр өдөрт 2-3 удаа хийж хэвших;
2. Халуун аарц, чацаргана нийт ажиллагсдад өдөрт 1 удаа олгох;
3. Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

Дөрөв. Хугацаа

2020.11.09-2020.12.11

Тав. Хамрах хүрээ

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн нийт ажиллагсад

Зургаа.Хариуцах эзэн

Захиргаа маркетингийн алба, Цусны чанар, аюулгүй байдлын алба

Долоо. Хамтран ажиллах

Төвийн бүх алба, тасгууд

Найм. Хүрэх үр дүн

Томуу, томуу төст өвчнөөс хэрхэн сэргийлэх чиглэлээр ажиллагсдын мэдлэг хандлага нэмэгдэн, дархлааг дэмжсэнээр өвчлөлөөс урьдчилан сэргийлж, ажлын бүтээмж нэмэгдэнэ.

ЦССҮТ-ийн Ерөнхий захирлын 2020 оны
... сарын 05 өдрийн А/1 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



**“ДАРХЛААГАА ДЭМЖИЦГЭЭ” аянд зарцуулагдах дархлаажуулалтын
төсөв**

№	Шаардагдах зүйлс	Савлагаа	Тоо, ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ Төг
1	Аарц	500 гр	100	4,419	441,900
2	Чацаргана	480мл	100	6,039	603,900
		Нийт			1,045,800